

**ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**
2025 оны 05 дугаар сарын 28-ны өдөр, Лхагва гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга	0
Хуралдааны товч тэмдэглэл:	1-1
Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	2-4
1. “Нэр дэвшигчийн сонсголын тов тогтоох, сонсгол даргалагчийг сонгох тухай” Байнгын хорооны тогтоолын төсөл	2-4

**Монгол Улсын Их Хурлын 2025 оны хаврын ээлжит чуулганы
Төрийн байгуулалтын байнгын хорооны 05 дугаар сарын 28-ны өдөр
/Лхагва гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл**

Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга Ж.Бат-Эрдэнэ ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 25 гишүүнээс 14 гишүүн хүрэлцэн ирж, 56.0 хувийн ирцтэйгээр хуралдаан 12 цаг 57 минутад Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

Чөлөөтэй: С.Амарсайхан, Э.Болормаа, Л.Гантөмөр, Л.Мөнхбаатар,
Л.Оюун-Эрдэнэ, Н.Учрал, Ц.Туваан, Э.Одбаяр;
Тасалсан: Н.Номтойбаяр, Ө.Шижир.

Нэг. “Нэр дэвшигчийн сонсголын тов тогтоох, сонсгол даргалагчийг сонгох тухай” Байнгын хорооны тогтоолын төсөл

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын ажлын албаны дарга бөгөөд Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Хатантуул, референт Б.Баярсайхан нар байлцав.

Тогтоолын төслийг Байнгын хорооны дарга Ж.Бат-Эрдэнэ танилцуулав.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Ж.Бат-Эрдэнэ: “Нэр дэвшигчийн сонсголын тов тогтоох, сонсгол даргалагчийг сонгох тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 5
Бүгд: 14
60.0 хувийн саналаар Байнгын хорооны тогтоол батлагдлаа.

Уг асуудлыг 13 цаг 05 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 1 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 09 минут үргэлжилж, 25 гишүүнээс 15 гишүүн хүрэлцэн ирж, 60.0 хувийн ирцтэйгээр 13 цаг 06 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА

Ж.БАТ-ЭРДЭНЭ

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААН ЗОХИОН
БАЙГУУЛАХ ХЭЛТСИЙН
ШИНЖЭЭЧ

Э.СУВД-ЭРДЭНЭ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2025 оны 05 дугаар сарын 28-ны өдөр, Лхагва гараг
Төрийн ордон “Жанжин Д.Сүхбаатар” танхим, 12 цаг 57 минут

ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Ж.Бат-Эрдэнэ: Байнгын хорооны эрхэм гишүүдийн энэ өдрийн амар амгаланг айлтгая. Ингээд байнгын хорооны хуралдаанд оролцож байгаа гишүүдийг та бүхэнд танилцуулъя.

Дашзэгвийн Амарбаясгалан гишүүн ирсэн байна. Баярмагнайн Баярбаатар гишүүн ирсэн. Тогмидын Доржханд гишүүн ирсэн. Бөхчулууны Пүрэвдорж гишүүн ирсэн. Одонгийн Цогтгэрэл гишүүн ирсэн. Жадамбын Бат-Эрдэнэ, Жудагийн Баярмаа гишүүн ирсэн. Сархадын Зулпхар гишүүн ирсэн. Цэндийн Сандаг-Очир гишүүн ирсэн. Лувсанцэрэнгийн Энх-Амгалан гишүүн ирсэн. Батын Батбаатар гишүүн ирсэн. Сандагийн Бямбацогт гишүүн ирсэн. Одсүрэнгийн Номинчимэг гишүүн ирсэн. Гончигдоржийн Уянгахишиг гишүүн ирсэн байна. Ингээд Байнгын хорооны гишүүдийн олонх хүрэлцэн ирж, ирц бүрдсэн тул Төрийн байгуулалтын байнгын хорооны 2025 оны 5 дугаар сарын 28-ны өдрийн хуралдааныг нээснийг мэдэгдье.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг та бүхэнд танилцуулъя. Байнгын хорооны хуралд хэлэлцэх 1 асуудал байна. Байнгын хорооны тогтоолын төсөл “Нэр дэвшигчийн сонсголыг тов тогтоох, сонсгол даргалагчийг сонгох тухай”.

Хэлэлцэх асуудалтай холбоотойгоор саналтай гишүүд байна уу. Алга байна. Ингээд сонсголд оролцох нэр бүхий хүмүүсийн танилцуулгыг та бүхэнд танилцуулъя.

Монгол Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хорооны 2018 оны 10 дугаар тогтоолоор баталсан Төрийн албан хаагчийн төлөөллийг сонгон шалгаруулах журмын 7.1-д “комисс үнэлгээг эцэслэн нягталж, онооны дарааллаар хамгийн эхэнд эрэмбэлэгдсэн оролцогчдын нэр, сонгон шалгаруулалт явуулсан тухай тайлан, холбогдох баримт бичгийг Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хороонд сонгон шалгаруулалт дууссанаас хойш 3 өдрийн дотор багтаан хүргүүлнэ.” гэж заасны дагуу нийт үнэлгээгээр хамгийн эхэнд эрэмбэлэгдсэн Цэнддаваагийн Амартөгс 87,1 оноотой, Бадамдоржийн Төгсцэнгэл 86,2 оноотой нарыг нэр дэвшүүлэн шалгаруулалтын тайлан болон холбогдох материалыг байнгын хороонд хүргүүлсэн.

Ц.Амартөгс эдийн засагч мэргэжилтэй. Төрийн удирдлага болон бизнесийн удирдлагын магистрын зэрэгтэй. Төрийн албанд 25 жил жил, үүндээ дэс түшмэлийн албан тушаалд 8,8, эрхэлсэн түшмэлийн албан тушаалд 12, тэргүүн түшмэлийн албан тушаалд 4,7 жил ажилласан туршлагатай. Үүнээс Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд хэлтсийн дарга, газрын орлогч дарга, газрын дарга, Төрийн албаны зөвлөлд хэлтсийн дарга, ажлын албаны дарга, Төрийн албаны зөвлөлийн гишүүнээр ажиллаж байна.

Тэрээр 1976 онд Улаанбаатар хотод төрсөн. 49 настай.

Б.Төгсцэнгэл эрх зүйч мэргэжилтэй, хуулийн магистрын зэрэгтэй. Төрийн албанд 15 жил, үүндээ ахлах түшмэлийн албан тушаалд 8, эрхэлсэн түшмэлийн албан тушаалд 5,5, тэргүүн түшмэлийн албан тушаалд 1 жил ажилласан туршлагатай. Үүнээс Улсын Их Хурлын Тамгын газрын Эрх зүй, хууль тогтоомжийн хэлтсийн шинжээч, референт, Хууль зүйн үйлчилгээний хэлтэс Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны референт, зөвлөх, Дотоод хяналтын хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч албан тушаалуудыг тус тус хашиж байна. Тэрээр 1978 онд Төв аймгийн Мөнгөнморьт суманд төрсөн. 47 настай.

Түүнчлэн төрийн албаны тухай хуулийн 68 дугаар зүйлийн 68.2-т заасны дагуу Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газраас Лхагвасүрэнгийн Золзаяаг Төрийн албаны зөвлөлд нэр дэвшүүлэхээр Улсын Их Хуралд ирүүлсэн байгаа.

Л.Золзаяа нь эрх зүйч мэргэжилтэй, бизнесийн удирдлага, олон улсын худалдааны магистрын зэрэгтэй. Төрийн албанд 23 жил 9 сар ажилласан туршлагатай. Үүнээс ТЕГ-т ахлах ажилтан, тасгийн дарга, газрын орлогч дарга, АТГ-т ахлах мэргэжилтэн, Гадаад харилцааны яаманд Бүгд Найрамдах Хятад Улсад суугаа Дипломат төлөөлөгчийн газарт Консул тэргүүн, Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газарт Хуулийн бодлогын газрын ахлах референтээр ажиллаж байна. Тэрээр 1977 онд Улаанбаатар хотод төрсөн. 48 настай гэсэн ийм 3 нэр дэвшигч байна.

Ингээд тогтоолын төслийг та бүхэнд уншиж танилцуулъя.

Монгол Улсын Их Хурлын байнгын хорооны тогтоол

“Төрийн албаны зөвлөлийн гишүүний албан тушаалд дэвшигчийн сонсголын тов тогтоох, сонсголын даргалагчийг сонгох тухай” Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.3.13 дахь заалт, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 122 дугаар зүйлийн 122.1 дэх хэсэг, 130 дугаар зүйлийн 130.1.1 дэх заалт, Нийтийн сонсголын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.1 дэх заалт, Төрийн албаны тухай хуулийн 68 дугаар зүйлийн 68.3 дахь хэсгийг үндэслэн Төрийн байгуулалтын байнгын хорооноос тогтоох нь:

1.Төрийн албаны зөвлөлийн гишүүнд нэр дэвшигч Цэнддаваагийн Амартөгс, Бадамдоржийн Төгсцэнгэл, Лхагвасүрэнгийн Золзаяа нартай хийх нэр дэвшигчийн сонсголыг 2025 оны 6 дугаар сарын 11-ний өдөр зохион байгуулахаар тогтсугай.

2.Нэр дэвшигчийн сонсгол даргалагчаар Улсын Их Хурлын гишүүн Б.Баярбаатарыг томилсугай.

3.Нэр дэвшигчээс асуух асуулт саналыг 2025 оны 6 дугаар сарын 10-ны өдрийг хүртэл хүлээн авахаар тогтсугай.

4.Нэр дэвшигчийн сонсголын талаар нийтэд мэдээлэх, сонсголын бэлтгэл хангах ажлыг холбогдох хууль журамд заасны дагуу зохион байгуулахыг Төрийн

байгуулалтын байнгын хорооны дарга /Ж.Бат-Эрдэнэ/-д даалгасугай гэсэн ийм тогтоолын төслийг та бүхэнд танилцуулж байна.

Тогтоолын төсөлтэй холбоотойгоор асуух асуулттай гишүүд байна уу. Алга байна. Тогтоолын төсөлтэй холбоотойгоор санал хэлэх гишүүд байна уу. Алга байна.

“Нэр дэвшигчийн сонсголын тов тогтоох, сонсгол даргалагчийг сонгох тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг баталъя гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 15 гишүүнээс 9 гишүүн оролцож, 60 хувиар тогтоол батлагдлаа.

“Нэр дэвшигчийн сонсголын тов тогтоох, сонсгол даргалагчийг сонгох тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг хэлэлцэж шийдвэрлэлээ.

Ингээд Төрийн байгуулалтын байнгын хорооны хэлэлцэх асуудал дууссан тул өнөөдрийн хуралдааныг хаасныг мэдэгдье.

Хурлаа хаахаас өмнө нэг зүйлийг бас та бүхэнд танилцуулъя. Өнөөдөр хуралдаанд ирсэн гишүүдийг дурдаадахъя. Оюунсайханы Алтангэрэл гишүүн ирсэн. Батын Батбаатар гишүүн ирсэн. Сандагийн Бямбацогт гишүүн ирсэн. Одсүрэнгийн Номинчимэг гишүүн ирсэн. Гончигдоржийн Уянгахишиг гишүүн ирсэн. Дашзэгвийн Амарбаясгалан гишүүн ирсэн. Баярмагнайн Баярбаатар гишүүн ирсэн. Тогмидын Доржханд гишүүн ирсэн. Бөхчулууны Пүрэвдорж гишүүн ирсэн. Одонгийн Цогтгэрэл гишүүн ирсэн. Жадамбын Бат-Эрдэнэ, Жудагийн Баярмаа гишүүн ирсэн. Сархадын Зулпхар гишүүн ирсэн. Цэндийн Сандаг-Очир гишүүн, Лувсанцэрэнгийн Энх-Амгалан гишүүд ирсэн.

Энэ дотроос одоо дандаа хүрэлцэн ирдэг гишүүд маань ирсэн байна. Тэгээд ирээгүй гишүүд Сайнбуянгийн Амарсайхан гишүүн, Лхагвын Мөнхбаатар гишүүн, Лувсаннамсрайн Оюун-Эрдэнэ гишүүн, Өлзийхүүгийн Шижир гишүүн, Энхбатын Болормаа гишүүн, Нямтайширын Номтойбаяр гишүүн, Цэвэгдоржийн Туваан гишүүн, Лувсаннъямын Гантөмөр гишүүн, Эрдэнэбилэгийн Одбаяр гишүүн, Ням-Осорын Учрал гишүүн гэсэн голцуу Засгийн газрын гишүүд маань ирээгүй байна.

Бид 2 цаг 30 минут хүлээсэн. Тэгээд цааш цаашдаа энэ ирээгүй, ер нь бол бол ирцээ харж байгаад ирээгүй гишүүд дээрээ бас журамдаа, дүрэмдээ өөрчлөлт оруулаад эсвэл хасдаг юм уу, яадаг юм. Арга хэмжээ авахгүй бол болохгүй байна шүү. Гишүүд маань бас энэ дээр анхаараарай гэдгийг та бүхэнд хэлье.

Ингээд Төрийн байгуулалтын байнгын хорооны өнөөдрийн бас хэлэлцэх асуудал дууссан тул хуралдаан хаасныг мэдэгдье.

13.06 цаг.

*ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ
ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ, ХЯНАСАН:
ШИНЖЭЭЧ*

Э.СУВД-ЭРДЭНЭ